



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№53 /497/

2023.03.31

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 119 ДҮГЭЭР АНГИД АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид ажиллаж өдөр тутмын үйл ажиллагаа, барилга байгууламж, зарим зэвсэглэл техниктэй танилцсаны зэрэгцээ ажилтан, цэргийн алба хаагчидтай уулзалт хийлээ.

Түүнийг дагалдаж ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын МТГ-ын дарга хурандаа Б.Түвшинтөр, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр нар ажиллалаа.

Батлан хамгаалахын сайдыг Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид хүрэлцэн ирэхэд химичин дайчид хүндэтгэн угтаж, ангийн захирагч дэд хурандаа Г.Дүнжингарав ангийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудаа уламжиллаа.

Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайд тус ангийн цэргийн зэвсэглэл техник, алба хаагчдын хувцас хэрэгсэл, барилга байгууламжуудтай

танилцаж холбогдох үүрэг чиглэлийг өгч ажилласны зэрэгцээ цэргийн нэрт зүтгэлтэн хошууч генерал Ч.Самбууг агсны хөшөөний нээлтэд оролцлоо.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хэлсэн үгэндээ амьдралынхаа ихэнх он жилүүдийг эх орноо батлан хамгаалах ариун үйлсэд зориулж хоёргүй сэтгэлээр зүтгэж ирсэн манлайлагчдын нэг бол хошууч генерал Ч.Самбуу болохыг онцлоод энд хүрэлцэн ирсэн гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, мөр зэрэгцэн ажиллаж байсан цэргийн нөхдийнх нь хамт түүний алдрыг мөнхжүүлэх арга хэмжээнд оролцож буйдаа баяртай байгаагаа илэрхийлсэн юм.

Хошууч генерал Ч.Самбуу нь Монгол Улсын Батлан хамгаалах салбарт 60 гаруй жил зүтгэн, томоохон албан тушаалуудыг хашиж, үүргээ нэр төртэй биелүүлж явсны дотроос түүний энэ ангитай холбоотой онцлогоос товчхон дурдвал тэрээр 1971-1976 онуудад тус ангийн захирагчаар ажиллах хугацаандаа ангиа 4 жил дараалан тэргүүний анги, 5 дахь жилдээ тухайн үеийн Монгол Ардын

Армийн онц ангийн болзлыг хангуулж улмаар уг анги төрийн дээд шагнал Алтангадас одонгоор шагнуулжээ. Ийнхүү түүний хичээл зүтгэл, эх орноо гэсэн хоёргүй сэтгэлийг төр, засаг өндрөөр үнэлж 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Алтангадас одонт Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийг хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит болгосон ажээ.

Арга хэмжээний төгсгөлд хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит Цацраг, химийн тагнуулын 2023 оны шилдэг тоот шалгаруулах тэмцээнд тэргүүлсэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын баг тамирчдад шагналыг нь гардууллаа. Уг тэмцээнд Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын 14 баг оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт хошууч О.Бат-Эрдэнэ ахлагчтай 119 дүгээр анги, дэд байрт хошууч Л.Галбадрах ахлагчтай 150 дугаар анги, гутгаар байрт ахлах ахлагч Г.Буянжаргал ахлагчтай 353 ангийн тамирчин дайчид тус тус шалгарч бусад нөхдөө манлайлсан юм.

Дэслэгч Ө.НАСАНТОГТОХ



"ЗЕНИТЧДИЙН ЦЭРГИЙН ГАЛ ТОГООНЫ БАЙРЫГ ШИНЭЧЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛНЭ"



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний 326 дугаар ангид ажиллаж өдөр тутмын үйл ажиллагаа, ангийн барилга байгууламж, зарим зэвсэглэл техниктэй танилцсаны зэрэгцээ ажилтан, цэргийн алба хаагчидтай уулзалт хийлээ.

Түүнийг дагалдаж ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын МТГ-ын дарга хурандаа

Б.Түвшинтөр, Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр нар ажилласан юм.

Батлан хамгаалахын сайдыг Зэвсэгт хүчний 326 дугаар ангид хүрэлцэн ирэхэд ангийн хүндэт харуулын бие бүрэлдэхүүн хүндэтгэн угтаж, ангийн захирагч хурандаа Г.Отгонбаяр ангийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудлуудаа уламжиллаа. Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын сайдаар ахлуулсан бие бүрэлдэхүүн тус ангийн

цэргийн зэвсэглэл техник, алба хаагчдын хувцас хэрэгсэл, барилга байгууламжуудтай танилцаж холбогдох үүрэг чиглэлийг өгсөн юм. Үүний дараагаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тус ангийн гал тогооны байрыг шинэчлэн сайжруулах тал дээр анхаарал хандуулахаа илэрхийллээ.

Арга хэмжээний төгсгөлд Батлан хамгаалахын сайд Зэвсэгт хүчний 326 дугаар нийт бие бүрэлдэхүүнтэй уулзалт хийж санал сэтгэгдлийг нь сонслоо.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
13	-9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	28

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,515	3,522
EUR	3,820	3,835
CNY	513	515
RUB	45.40	45.70
JPY	26.90	27.10
KRW	2.71	2.73

ЗУРХАЙ

2023.03.31 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 10

ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН ТУУЛАЙ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР ХУЛГАНА ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:

Эрч хүч ихэснэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.34-19.19

БАРИЛДЛАГА:

Түлэх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Өтлөх үхэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй б

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 683,849,891

Эдгэрсэн

Нийт: 656,758,944

Нас барсан

Нийт: 6,830,728

Цаг үе, үйл явдал

ЭНЭ ЖИЛ “ОЮУТАН-ЦЭРЭГ” ХӨТӨЛБӨРТ ОРОН НУТГИЙН ОЮУТНУУД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ



олгох сургалтад хамрагдах их, дээд сургуулийн оюутан, МСҮТ-ийн суралцагчдын тоог шат дараатай нэмэгдүүлнэ” хэмээн зааж, жил бүр хамрагдах оюутан, суралцагчдын тоог 500-гаар нэмэгдүүлэхээр тусгасан боловч 2020, 2021 онуудад дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас завсардаж, 2022 онд нийслэл дэх их, дээд сургуулийн 451 оюутан, коллеж, МСҮТ-ийн суралцагчдыг хамруулсан.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 3 дугаар сарын 23-ны өдөр оюутан, залуустай хийсэн уулзалтын үеэр “Оюутан-цэрэг” хөтөлбөрт хамрагдах залуусын тоог нэмэгдүүлэх талаар нэлээд санал гарсан. Тиймээс Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар тус хөтөлбөрт хамрагдах оюутан, суралцагчдын тоог энэ жил 1500-д хүргэхээр шийдвэрлэсэн.

Түүнчлэн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр уг шийдвэртэй холбогдуулан ойрын жилүүдэд хамрагдаж чадаагүй орон нутаг дахь их, дээд сургууль, коллежийн оюутан, МСҮТ-ийн суралцагчдыг “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Ташрамд дурдахад, “Оюутан-цэрэг” сургалтын бүртгэлийг төрийн нэгдсэн цахим үйлчилгээний цонх “E-Mongolia”-аар бүртгэх, бүртгүүлж байгаа оюутан, суралцагчдын нас, сургууль, дамжаа, сурлагын голч дүнгийн мэдээллийг Боловсролын ерөнхий газар, Боловсролын мэдээлэл, технологийн төвөөр баталгаажуулах, баталгаажсан оюутан, суралцагчийн мэдээллийг авч сонгон шалгаруулалт хийхээр Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран 3 дугаар сарын 6-17-ны өдрүүдэд цахим бүртгэлийг явуулсан бөгөөд нийслэл дэх их, дээд сургуулиудын 1000 гаруй оюутан бүртгүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар “Оюутан-цэрэг” хөтөлбөрт хамрагдах оюутан, суралцагчдын тоог энэ жил 1500-д хүргэхээр шийдвэрлэсэн. Үүнтэй холбогдуулан БХЯ-наас хэвлэлийн бага хурал зохион байгуулж, тодорхой мэдээллийг өглөө.

Улс орны батлан хамгаалах чадавхыг сайжруулах, дайчилгааны бэлтгэл үүрэгтний нөөцийг нэмэгдүүлэх, төрийн алба хаших, батлан хамгаалах бэлтгэлжилтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор оюутан залуусыг их, дээд сургуульд суралцах хугацаандаа цэргийн алба хаах боломжийг бүрдүүлсэн нь тэдгээрийг цэрэг-эх оронч үзэл, хүмүүжилтэй, эх орноо батлан хамгаалах эрүүл чийрэг, бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтэй болгон төлөвшүүлж байгаа нь олон нийтийн дэмжлэгийг авч, тус сургалтын эрэлт, хэрэгцээ жилээс жилд нэмэгдэж байна.

Энэ хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “Оюутан-цэрэг” цэргийн мэргэжил



ЗХЖШ-ЫН ДАРГА ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 310 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА



ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй албаныхан Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 310 дугаар ангид ажиллалаа. Энэ үеэр тус ангийн захирагч дэд хурандаа Б.Өлзийдэлгэр ангийнхаа үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулж, тулгамдаж буй асуудлуудаа уламжиллаа. Үргэлжлүүлэн албаныхан ангийн өдөр тутмын үйл ажиллагаа болон агуулахууд, “Найман шарга” амралтын газрын барилга байгууламжтай танилцсан юм.

Зэвсэгт хүчний 310 дугаар анги энэ жилийн тухайд Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөр,

төлөвлөгөөний биелэлтийг хангахад материал хэрэгслийн хангалт, хадгалалт, тээвэрлэлт, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг чанартай гүйцэтгэж, бие бүрэлдэхүүний манлайлал, байгууллагын соёлыг дээшлүүлэх зорилго дэвшүүлэн өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж байна.

Түүнчлэн бие бүрэлдэхүүнээ ажлын байранд нь хөгжүүлэх төрөл бүрийн бүтээлч санаачилгыг хэрэгжүүлж, 10 дугуйлан, 8 клуб хичээллүүлэн давхардсан тоогоор 300 гаруй алба хаагчийг хамруулан бие хүний хөгжилд нь анхаарч байгаа аж.

Ахлах дэслэгч Ц.НАМЖИЛМАА
Гэрэл зургийг ахлагч Н.БАТТӨМӨР



Цахим шууданд

АХЛАХ АНГИЙН СУРАГЧДАД ЦЭРГИЙН ҮҮРЭГТНИЙ ҮНЭМЛЭХ ГАРДУУЛАА



хууль тогтоомж, хугацаат цэргийн алба хаахын давуу талуудын талаар мэдээлэл хийж, эх орныхоо өмнө хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлэх боломж нээгдэж байгаад баяр хүргэлээ.

Тодруулбал, аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёл “Цэргийн үүрэгтний үнэмлэх гардан авснаар эх орон, ард түмнийхээ өмнө хариуцлагатай үүрэг хүлээсэн иргэн болж байна гэсэн үг. Энэ бол бахархам бөгөөд хариуцлагатай үүрэг. Үндсэн хуулиа дээдлэн иргэний үүргээ биелүүлэн эх орныхоо халдашгүй дархан байдлыг сахин хамгаалах үйлсэд гар бие оролцох их үүрэг таны өмнө ирлээ” хэмээн амжилт хүсэж байв.

Үнэмлэх гардуулах ёслолын үеэр Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн үйл ажиллагааг сурагчдад сурталчилсан нь тэдний цэргийн албаар бахархах үзлийг улам батжуулж чадсан юм.



Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургуулиудын XII ангийн сурагчдад цэргийн үүрэгтний үнэмлэх гардуулах арга хэмжээг Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажилтай уялдуулан зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч Ш.Ёл, Цэргийн штабын дарга, хурандаа О.Ганзориг, Хэрлэн сумын ЗДТГ-ын дарга А.Наранцэцэг нарын албаныхан оролцсон юм.

Ахлах ангийн сурагчдад Батлан хамгаалах салбарын

АХМАДУУДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн хамт олон, ахмадын зөвлөл хамтран 1970-1990 он хүртэл Дархан хотод байрлаж үйл ажиллагаа явуулж байсан Монгол Ардын Армийн 134 дүгээр ангийн ахмадуудаа эргэж хүндэтгэл үзүүлэх зорилгоор дурсамж уулзалтыг зохион байгууллаа.

Уг уулзалтад Монгол Ардын

Армийн 134 дүгээр ангийн үе үеийн захирагч, захирагчийн орлогч, албад салбаруудын дарга нарын тэргүүтэй 63 хүн оролцлоо. Ахмадуудаа хүндэтгэх эл арга хэмжээг Агаарын цэргийн ууган дарга нарын нэг хурандаа Г.Эрдэнэцогтын санаачилгаар 2011 оноос хойш уламжлал болгон зохион байгуулж байгаа юм.